

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### 1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль/шинэчилсэн найруулга/
- ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах нийтлэг журам”
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
- Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны тухай хууль/шинэчилсэн найруулга/, 2018,12,07

Дагаж мөрдөх огноо: 2019.01.01

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:	<b>2023.01.18</b>
Байгууллагын нэр: <b>Сумын Эрүүл мэндийн төв</b>	Нэгжийн нэр: <b>Эрүүл мэндийн төв</b>
Албан тушаалын нэр: <b>Сумын Эрүүл мэндийн төвийн дарга</b>	Албан тушаалын ангилал, зэрэглэл: <b>Төрийн үйлчилгээний эрүүл мэндийн 6</b>
Ажлын цаг: <b>Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гаригийн 09:00-13:00, 14:00-18:00</b>	Ажлын байрны албан ёсны байршил: <b>Төв аймгийн Борнуур сум</b>
Хөдөлмөрийн нөхцөл: <b>Хэвийн</b>	Онцгой нөхцөл:

### 2.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

#### Албан тушаалын зорилго:

Сумын иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чанартай хүргэхэд эрүүл мэндийн төвийн хамт олныг нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

#### Албан тушаалын зорилт:

Зорилт 1. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Зорилт 2. Сумын Эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт/MNS50:81-2013/-ын хангалтыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд жигд, хүртээмжтэй, чанартай хүргэнэ

Зорилт 3. Эрүүл мэндийн салбарт хэрэгждэг бодлого, стратеги, хөтөлбөрүүдийг сум орон нутгын онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Эрүүл мэндийн төвийг ерөнхий удирдлагаар хангана Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг 3-5 жил тутам, чанарын хөтөлбөрийг магадлан итгэмжлэл сунгуулах бүр хийж, хэрэгжилтийг ханган ажиллана	Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	Г, Х, Ш
	Хүний нөөцийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар хянуулан батлуулж, Албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын эрхэм зорилго,	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Г, Х, Ш

	зорилттой уялдуулан шинэчилж, боловсронгуй болгон мөрдүүлнэ		
	Сумын Засаг даргаар жил бүр ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана	Ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр	Г, Х, Ш
	Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ, мэргэжлийн албан хаагчидтай ажлын гүйцэтгэлийн гэрээ байгуулан улирал тутам дүгнэнэ	Ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнгээр	Г, Х, Ш
	Эмнэлгийн дотоод журам, амбулаторийн үзлэгийн журам зэрэг ЭМСалбарт мөрдөгдөх журам, удирдамжуудыг байгууллагынхаа хэмжээнд боловсруулан мөрдөн ажиллана	Удирдамжийн хэрэгжилтээр	Г, Х, Ш
	Эрүүл мэндийн төвийн сар, улирал тутмын мэдээ тайланг үнэн зөв гарган холбогдох газарт нь хугацаанд нь мэдээлж ажиллана	Мэдээний нэгдсэн дүнгээр	Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	“Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдэл”, “Эмийн зохистой хэрэглээ”, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Түгээмэл үйлдлийн стандар”, стандартуудыг хэрэгжүүлэхэд хамт олноо удирдан зохион байгуулж, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлнэ	Бодлого, стандартын хэрэгжилтээр	Г, Х, Ш
	Эмнэлгийн орчин, барилга байгууламж, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлийг хугацаанд нь хийлгэн тоног төхөөрөмжийн хангалтыг жил бүр нэмэгдүүлнэ	Хэрэгжилтийн хувиар	Х, Ш
	Сумын хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчин, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг графикын дагуу чанартай, үр дүнтэй зохион байгуулна	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, эмчлэн эрүүлжүүлэлтээр	Г, Х, Ш
	Эх, нялхасын эрүүл мэндийн төлөө хамтдаа үйл ажиллагааг нэн тэргүүний ажлаа болгон ажиллаж, эх хүүхдийн эндэгдлийг бууруулах ажлыг хийнэ	Эх, нялхасын эндэглийн түвшингээр	Г, Х, Ш
	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулна	Ажлын гүйцэтгэлээр	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	Ниймгийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлнэ	Бодлогын хэрэгжилтээр	Г, Х, Ш
	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг ханган ажиллана	Хөтөлбөр, стратегийн хэрэгжилтээр	Г, Х, Ш
	Аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, жил бүрийн үндсэн чиглэлд тусгагдсан ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллана	Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар	Г, Х, Ш

### 3.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
<b>Мэргэжил</b>	Хүний их эмч мэргэжилтэй
<b>Мэргэшил</b>	Удирдах арга барил эзэмших болон удирдлагын сургалтанд хамрагдсан байх

<b>Туршлага</b>		Эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан байх
<b>Ур чадвар</b>	Дүн шинжилгээ хийх	Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй Мэдээллийн технологийн хэрэглээний программ бүрэн эзэмшсэн.
	Асуудал шийдвэрлэх	Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах
	Багаар ажиллах	Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах
<b>Хууль тогтоомжинд заасан бусад шаардлага</b>		Ашиг сонирхлын зөрчилгүй байх

#### 4.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

Бусад харилцах объект:

1. Эрүүл мэндийн төвийн их эмч
2. Эрүүл мэндийн төвийн бага эмч, сувилагч
3. Үйлчилгээний ажилтан

- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Сумын Засаг дарга, Тамгын газрын дарга
- Сумын Нийгмийн бодлогын ажилтан
- Тамгын газар, Соёлын төв, ЕБСургууль, цэцэрлэгийн дарга эрхлэгч, мэргэжилтнүүд

#### 5.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянасан:

Албан тушаал:

Албан тушаал:

БОРНУУР СУМЫН ЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН АЖИЛТАН

БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

.....  
3. ОЮУНСҮРЭНЧАГДАЛ

..... Т.ӨЛЗИЙБУЯН

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА

Шийдвэрийн огноо: 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар: 01

Тамга/тэмдэг

БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА ..... Н.УНДРАХБИЛЭГ

2023 оны 1 дүгээр сарын 18 ний өдөр